Mongol - Муу Оюун Судрууд - Bad Mind Scriptures

Эхлэл 26:35 Тэд нь Исаак, Ребека хоёрт сэтгэлийн зовлон болжээ.

Дэл хууль 28:65 Чи тэдгээр үндэстний дотор амар амгаланг олж чадахгүй, хөлөө амраах газар ч олж чадахгүй. Харин тэнд ЭЗЭН зүрхийг чинь чичрүүлж, зовхийг чинь буулган, сэтгэлийг чинь самууруулна.

Рут 1:18 Тэр түүнийг өөртэй нь хамт явахаар эрс шийдсэнийг хараад, түүнд дахин юу ч өгүүлсэнгүй.

2 Самуел 17:8 Тэгээд цааш нь Хушаи — Хээр тадд бамбаруушаа булаалгасан эвшийн адил эцэг чинь болон түүний цэргүүд нь догшин, хүчтэй эрчүүд гэдгийг чи мэднэ. Чиний эцэг дайнд мэргэшсэн гаргууд хүн. Тэрээр ардуудтай хамт шөнийг өнгөрүүлэхгүй.

Сургаалт Үгс 21:27 Хар санаатны өргөл нь ч бузар бол Хорон муу санаа өвөрлөн өгсөн түүний өргөл ямар их бузар зүйл байх билээ!

Сургаалт Үгс 29:11 Мунхаг хүн уур уцаараа барьж үл чадна. Харин мэргэн хүн уурыг барьдаг.

Езекиел 23:17,22,28 Тэгээд вавилончууд тэр эмийн дурлалын орон дээр ирж, өөрсдийн садар самуунаараа тэр эмийг бузарлав. Тэр тэднээр бузарлагдмагц түүний сэтгэл тэднийг жигшив. 22 Тиймийн тулд Охолиба, Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. "Харагтун, Би чиний хөндийрсөн амрагуудыг чинь босгож, тэднийг зүг бүрээс чиний эсрэг авчирна. 28 Учир нь Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. "Харагтун, чамайг Би үзэн яддаг хүмүүсийн чинь гарт, чиний хөндийрсэн хүмүүсийн гарт тушаана.

Езекиел 36:5 Тиймийн тулд Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. «Үнэхээр Өөрийн хардалтын гал дотор Би бусад үндэстнүүд болон бүх Едомын эсрэг айлджээ. Тэд Миний нутгийг олз болгон таслан авахын тулд зүрхнийхээ угаас баярлан, сэтгэлээрээ элэглэж, өөрсөддөө өмч болгон өгсөн юм».

Езекиел 38:10 Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. «Тэр өдөр чиний оюун ухаанд бодлууд төрж, чи хорон муу төлөвлөгөө сэднэ.

Даниел 5:20 Харин түүний зүрх ихэмсэг болж, түүний сэтгэл маш бардам болсноос тэрээр дээрэнгүй загнах үедээ хаан ширээнээсээ хаягдаж, сүр жавхлан нь түүнээс зайлав.

Лук 12:29 Юу идэх, юу уух билээ гэж та нар бүү хайгтун. Санаа зовохоо боль.

Үйлс 12:20 Херод Тир болон Сидоны хүмүүст ихэд хилэгнэдэг байв. Тэндхийнхэн хааны нутгаас хоол хүнсээр хангагддаг байсан тул хааны түшмэл Бластыг талдаа татаж нэгэн санаагаар түүн уруу ирж найрамдахыг гуйжээ.

Үйлс 14:2 Харин үл итгэгч иудейчүүд Харь үндэстнүүдийн бодол санааг үймүүлж, тэднийг ах дүүсийн эсрэг турхирч байлаа.

Ром 1:28 Тэд Бурханыг мэдэх нь зохистой гэж үзээгүй шиг, Бурхан тэднийг ёс суртахуунгүй оюун санаанд тушаав. Тэд хийх ёсгүй зүйлсийг үйлдэх болсон бөгөөд

Ром 8:6,7 Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой. 7 Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол

Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы хуульд захирагддаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй.

Ром 11:20 Тийм ээ, тэд итгэлгүйгээс болж тастагдсан. Харин та итгэлээрээ зогсож байна. Бүү ихэмсэг бай, харин эмээгтүн.

2 Коринт 10:5 Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг.

2 Коринт 11:3 Гэвч могой залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ уруу хандсан цэвэр, энгийн байдлаас та нарын санаа бодлуудыг төөрүүлчих вий гэхээс би айж байна.

Ефес 2:3 Тэдний дунд бид ч бас бүгдээрээ урьд нь махан бие болон санаа бодлын хүслүүдээ өөгшүүлэн махан биеийнхээ хүсэл тачаалууд дотор амьдарч байв. Мөн бусдын адил төрөлхөөс уур хилэнг хүртэх хүүхдүүд байсан.

Ефес 4:17 Тиймээс би Эзэний дотор үүнийг хэлж, гэрчилье. Харь үндэстнүүд оюун санааны хоосрол дотроо явдаг шиг та нар цаашид тэгж явж болохгүй.

Колоссай 1:21 Хэдийгээр та нар урьд нь холдуулагдсан бөгөөд бузар үйлсээрээ оюун ухаан дотроо дайснууд болсон боловч

Колоссай 2:18 Хуурамч даруу байдалд таашаал аван, тэнгэр элч нарт мөргөдөг, үзсэн үзэгдлээ баримтлан, махан биеийн ухаанаар өөрийгөө дэмий хоосон дөвийлгөдөг ямар ч хүн та нарын шагналыг бүү булааг.

1 Тесалоник 5:14 Ах дүү нар аа, эмх журамгүй хүмүүст сануулж, хулчгар хүмүүсийг зоригжуулж, дорой буурай хүмүүст тусалж, бүх хүнд тэвчээртэйгээр хандахыг бид та нараас гуйж байна.

2 Тесалоник 2:2 Эзэний өдөр ирчихлээ хэмээн та нар ухаан бодлоороо тэр даруй ганхаж дайвалгүй, эсвэл сүнсээр ч юм уу, эсвэл үг яриагаар ч юм уу, эсвэл биднээс ирсэн мэт захидлаар ч үймүүлэгдэхгүй байгтун.

1 Тимот 6:5 ялзарсан оюун ухаантай, үнэнгүй болсон, бурханлаг байдлыг ашиг хонжоо олох хэрэгсэл гэж боддог хүмүүсийн хоорондох байнгын маргаан гардаг байна.

2 Тимот 3:8 Ианн, Иамбре хоёр Мосегэсэргүүцсэн шиг, тэдгээр хүмүүс үнэнийг эсэргүүцдэг. Тэд ялзарсан санаа бодолтой, итгэлийн хувьд гологдсон хүмүүс юм.

Тит 1:15 Цэврийн хувьд бүх юмс цэвэр ажээ. Харин бузартсан болоод итгэлгүй хүмүүсийн хувьд юу ч цэвэр биш. Харин тэдний ухаан ба мөс чанар нь хоёулаа бузартсан байдаг.

Еврей 12:3 Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Түүнийг санагтун. Тэрээр Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн ажээ.

Иаков 1:8 Тэр хүн хоёр санаа өвөрлөгч бөгөөд бүх үйлдээ тогтворгүй байдаг юм.

Pastor T. John Franklin
Church of Salvation, Healing, and Deliverance
COS-HAD.org